



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2021/01



ГАРЧИГ

Товч танилцуулга.....	1-13
Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	14
Нэг. Эрүүл мэнд.....	15-16
Хоёр. Хөдөлмөр эрхлэлт	17-19
Гурав. Нийгмийн даатгал, халамж.....	20-23
Дөрөв. Гэмт хэрэг.....	24-25
Тав. Мөнгө,зээл	26
Зургаа. Төсөв, санхүү	27-28
Долоо. Үнэ.....	29-32
Найм. Хөдөө аж ахуй	33-34
Ес. Аж үйлдвэр.....	35-39
Арав. Байгаль орчин	40



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2021 оны 01 дүгээр сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт




1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2021 оны 01 сард 122 эх амаржиж, 123 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 26(17.6)-аар, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 26(17.4)-аар тус тус буурсан байна. 2021 оны 01 сарын байдлаар 35 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс 6(25.7)-аар буурчээ.

Хүн амын цэвэр өсөлт 97 болж 2020 оны мөн үеийнхээс 17(14.9)-оор буурсан байна. 1000 хүнд ногдох төрөлт 1.8, нас баралт 0.4 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.4 пунктээр, нас баралт 0.1 пунктээр тус тус буурсан байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2018-2021 оны 01 сард



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд нялхсын эндэгдэл 2 байна.



1.2 Эрүүл мэнд

2021 оны 01 сарын байдлаар 35.3 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 20.9 хувиар, 1.2 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 42.9 хувиар тус тус буурч, 1.2 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 20.0 хувиар өсчээ.


2021 оны 01 сард 184 эх жирэмсний хяналтанд орсны 87.5 хувь буюу 161 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 5.6 пунктээр буурсан байна.



Түргэн тусламжийн дуудлага 1,5 мянган удаа гарсны 0.2 мянга буюу 13.3 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 48.3 хувиар, алсын дуудлага 50.0 хувиар тус тус буурсан байна.

Он гарсаар ослын улмаас 182 хүн бэртэж, 3 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 56(23.5%)-аар, нас барсан хүний тоо 2(40.0%)-оор тус тус буурчээ.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2021 оны 01 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд хавдар 46.2 хувийг, бусад төрлийн өвчин 26.9 хувийг, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 15.4 хувь, осол гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралт 11.5 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 28 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 93-аар буюу 23.1 хувиар буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад заг хүйтэн 64.0 хувиар, трихоминиаз 61.5 хувиар, тэмбүү 50 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.



1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн


Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2021 оны 1 сарын эцэст 276 болсны 243 (88.0%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 33 (12.0%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 33(13.6%) хүнээр нэмэгдэж, өмнөх сараас 18 (6.1%) хүнээр буурчээ.



Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 135(48.9%) нь бүрэн дунд, 82(29.7%) нь дээд, 15(5.4%) нь техник мэргэжлийн, 22(8.0%) нь тусгай дунд, 14(5.1%) нь бүрэн бус дунд, 2(0.7%) магистр, докторын боловсролтой, 2(0.7%) нь бага, 4(1.4%) нь боловсролгүй иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2021 оны 01 сарын эцэст



Хөдөлмөрийн хэлтэст 2021 оны эхний 1 сарын байдлаар бүртгэлтэй байсан 15 иргэн ажилд зуучлагдан орж, өмнөх сарын бүртгэлээс 108 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар хасагдсан байна.




1.4 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны 01 сарын байдлаар 3882.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1068.8 (38.0%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны 01 сард өмнөх оны мөн үеэс 1068.8 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 825.0 (46.3%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 183.9 (39.2%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 74.2(37.1%) сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.




Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2021 оны 01 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 4771.7 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 443.9(10.3%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 3832.7(80.3%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 489.1(10.3%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 258.1(5.4%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 109.4(2.3%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 82.4(1.7%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг






Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2021 оны 1 сард нийгмийн халамжийн сангаас 6006 иргэнд 595.7 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамжийн тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд 1464(19.6%)-аар буурч, олгосон тэтгэвэр тэтгэмж 72.5(33.2%) сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2021 оны 1 сард 1252 хүн хамрагдсан нь өмнөх оноос 20(1.6%)-оор өсч, олгосон тэтгэвэрийн хэмжээ 371.7 сая төгрөг болж 153.6(70.4%) сая төгрөгөөр өсчээ.


Нийгмийн халамжийн тэтгэмж 1024 иргэнд 101.6 сая төгрөг, амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 288 иргэнд 75.2 сая төгрөг болон нийгмийн халамжийн сангийн зардлыг 2 иргэнд 2.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 3440 иргэн хамрагдаж, 44.8 сая төгрөгийг олгожээ.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/






1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2021 оны эхний 01 сарын байдлаар 31 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 12 хүн гэмтэж, 3 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 24 (43.6%)-өөр буурсан. Гэмтсэн болон нас барсан хүний тоо өмнөх оны мөн үетэй адил байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүн амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 1(33.3%)-ээр, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 1(10.0%)-ээр, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 11(55.0%)-ээр, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 6(85.7%)-аар тус тус буурч, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1(2 дахин)-ээр, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 2(3 дахин)-оор, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1(2 дахин)-ээр тус тус нэмэгдсэн байна.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар




Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 29.0 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 29.0 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 9.7 хувийг олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, 6.5 хувийг хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 6.5 хувийг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 6.5 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 3.2 хувийг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, 9.6 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна.

Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 2 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2(50.0%)-оор буурсан байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Мандах, Хөвсгөл, Сайншанд сумдад нэмэгдэж, Өргөн, Эрдэнэ сумдад өмнө онтой адил, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.




Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 40.8 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 84.2(67.4%) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 27.8(68.1%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 12(38.7%) нь гэр орон сууцандаа, 2(6.5%) нь согтуугаар, 3(9.7%) нь гудамж олон нийтийн газарт, 2(6.5%) бүлэглэн, 5(16.1%) хувийг эмэгтэй хүн оролцон, 5(16.1%) нь шөнийн цагаар /22-06 цагт/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 88 хүн саатуулагдаж, 8 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2021 оны 01 сард






Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




2.1 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын зээлдэгчийн тоо 35.4 мянга болж өмнөх оноос 0.6(1.7%) мянган хүнээр буурч, нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо 79.5 мянга болж өмнөх оны мөн үеээс 9.2 хувиар өссөн байна.

Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2020-2021 он, сая.төг



Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2020-2021 он, мян.хүн




Нийт хадгаламжийн үлдэгдэл 164.3 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 2066.2 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 2353.3 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Хадгаламжийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45.4(38.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл сарын эцэст 7.3 тэр бум төгрөг болж, өмнөх сараас 0.8(10.4%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2.2(42.3%) тэр бум төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.9 хувийг эзэлж, өмнөх сараас 0.3 пунктээр буурч, өмнөх оны мөн үеэс 1.1 пунктээр өсчээ.


Чанаргүй зээл сарын эцэст 12.9 тэр бум төгрөг болж, өмнөх сараас 1101.8(8.5%)сая төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 5118.3(65.0%) сая төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.7 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 2.3 пунктээр өссөн байна.



Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2021.01 сард



Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2021.01 сард




2.2 Төсөв, санхүү

2021 оны 1 дүгээр сарын байдлаар орон нутгийн төсөвт 2091.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 65.8 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 24.0 хувиар буурсан байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 93.9 хувийг татварын, 6.1 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.



Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2021 оны 01 сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр, ус бохирдуулсны төлбөр нийт 560.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 73.4 хувь буюу 1544.3 сая.төг-өөр буурч, төлөвлөгөөнөөс 1.5 хувь буюу 8.4 сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Хэрэглээний үнийн индекс 2021 оны 01 дүгээр сарыг өмнөх сартай харьцуулахад 0.9 хувиар, өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар тус тус өсчээ.

Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 0.9 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 2.6 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 0.4 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 1.2 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 0.1 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.


Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.4 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 8.7 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 0.6 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 6.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.6 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 4.8 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 6.7 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 0.1 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 3.4 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2021 оны 01 дүгээр сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)




Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2020-2021 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)





Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2017-2021 оны 01 дүгээр сар (өмнөх оны 12-р сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



3.1 Хөдөө аж ахуй

Том малын зүй бус хорогдол 2021 оны эхний 01 сард аймгийн хэмжээнд 8965 болж, өмнөх оны мөн үеэс 8920(199 дахин) толгойгоор нэмэгдсэн байна. Нийт хорогдсон малын 53.1 хувийг ямаа, 36.5 хувийг хонь эзэлж байна. Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд, Сайншанд сумдад цасан бүрхүүл ихтэй, өвөлжилтын байдал хүнд учраас хорогдол ихтэй байна.

Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Улаанбадрах, суманд хамгийн их буюу 1300.0 мянган төгрөг, Алтанширээ, Хатанбулаг, Эрдэнэ сумдад хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг, соёолон үрээ Өргөн суманд хамгийн их буюу 1000.0 мянган төгрөг, Мандах, Сайхандулаан сумдад хамгийн бага буюу 700.0 мянган төгрөг, хязаалан гуна Өргөн суманд хамгийн их буюу 1400.0 мянган төгрөг, Хатанбулаг суманд хамгийн бага буюу 700.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Эрдэнэ суманд хамгийн их буюу 250.0 мянган төгрөг, Алтанширээ, Сайхандулаан суманд хамгийн бага буюу 120.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Айраг, Эрдэнэ суманд хамгийн их буюу 180.0 мянган төгрөг, Алтанширээ суманд хамгийн бага буюу 80.0 мянган төгрөг байна.



3.2 Аж үйлдвэр

2021 оны 01 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 8770.7 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 14620.4 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 96.0 хувиар өсч, борлуулалт 63.9 хувиар буурсан байна.

2021 оны 01 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 96.0 хувиар өсөхөд уул, уурхай олборлох салбарын үйлдвэрлэлт өмнөх оноос 3688.8 сая төгрөгөөр, боловсруулах салбарын үйлдвэрлэлт 321.0 сая төгрөгөөр, цахилгаан, хий, уур агааржуулалтын салбарын үйлдвэрлэлт 215.9 сая төгрөгөөр, усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон



хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын үйлдвэрлэлт 70.6 сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 16.0 хувийг төрийн, 84.0 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 16.0 хувь, компани 82.9 хувь, өрхийн аж ахуй 1.1 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад савласан цэвэр ус 82.3 мян.литрээр, нарийн боов 2.9 тонноор, хиам 3.1 тонноор, шохой 1000.0 тонноор, нүүрс 20.8 тонноор, вакуум цонх 5.2 м²-аар, цемент 3.4 мян.тонноор, дээл 4 ширхгээр тус тус илүү үйлдвэрлэгджээ.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин Цаг уур

Температур: 1-р сарын дундаж агаарын температур Мандах, Хөвсгөл, Сайхандулаан, Улаанбадрах, Хатанбулаг сумдад -12.2...-16.4 градус, бусад сумдад -19.0...-21.2 градус, агаарын хамгийн их температур өдөртөө Мандах, Хөвсгөл сумдад 2-4 градус дулаан, бусад сумдад -1...-6 градус хүйтэн байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Айраг, Иххэт сумдад ОЖД-ийн орчим, Мандах, Аланширээ, Сайхандулаан, Улаанбадрах, Хатанбула сумдад ОЖД-аас дулаан, бусад сумдын нутгаар ОЖД-аас хүйтэн байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө -11...-22 градус, өдөртөө Эрдэнэ суманд -1 градус хүйтэн, бусад сумдын нутгаар 0-12 градус дулаан байв.

Хур тунадас: 1 дүгээр сард нийт нутгаар цас орж 1...4 өдөр хур тунадастай байж, 0.0...2.9 мм цас орлоо. Орсон хур тунадасны нийлбэрийг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Сайншанд, Хөвсгөл, Дэлгэрэх, Эрдэнэ, Айраг, Өргөн сумдад ОЖД-аас ахиу, Замын-Үүд, Мандах, Сайхандулаан, Улаанбадрах сумдад ОЖД-аас бага, Аланширээ, Иххэт, Хатанбулаг сумдад ОЖДундаж орчим цас орсон байна.

Салхи: Энэ сард салхины хамгийн их хурд Мандах суманд 21 метр, бусад сумдын нутгаар 10-14 метр хүрсэн. 10м/с-ээс дээш салхитай хоногийн тоо 2...7 өдөр байлаа.

Цасан бүрхүүлийн байдал: 1 дүгээр сарын 31-ний байдлаар Эрдэнэ, Алтанширээ, Өргөн сумдад 10 баллын 5-7 см, Замын-Үүд, Хөвсгөл, Айраг, Иххэт Дэлгэрэх, Сайншанд сумдад 5-9 баллын 1-6 см, Сайхандулаан, Улаанбадрах сумдад 1-4 баллын цасан бүрхүүлтэй, Мандах, Хатанбулаг сумдын нутгаар цасгүй байв.

_____ о О о _____

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**
(2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН БАЙДЛААР)**I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд**

	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2021 2020
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	мянган хүн	69.6	69.8	69.8	69.6	99.7
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	126	110	149	123	82.6
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	24	41	35	26	74.3
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	102	69	114	97	85.1
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	1	0	1	2	2.0 ²
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	7.9	0.0	6.7	16.3	2.4 ²
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 025	879	243	276	113.6
- Үүнээс эмэгтэй	тоо	517	417	114	139	121.9
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	237	203	52	64	123.1
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	2	1	0	0	
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	1		0	0	
Улирлын чанартай ажлын байр	тоо	0	1	0	0	
Түр ажлын байр					0	
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	41	85	121	417	3.4 ²
- 10000 хүнд ногдох	тоо	6	12	17	60	3.4 ²
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	43	65	55	31	56.4
- 10000 хүнд ногдох ***	тоо	10	15	12	7	56.4
6. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	7989.1	13338.8	4474.4	8770.7	196.0
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	14531.1	24489.3	18553.0	14620.4	78.8

* - 2018,2018,оны жилийн эцэст, 2020 он урьдчилсан байдлаар

**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2020 I	2021 I	Өсөлт	
		Тоо			Хувь
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	44.6	35.3	-9.3	79.1
2. Ор хоног	мян.хүн	14.3	8.1	-6.2	56.6
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	1.0	1.2	0.2	120.0
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	2.1	1.2	-0.9	57.1
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	2.9	1.5	-1.4	51.7
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	0.4	0.2	-0.2	50.0
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	238	182	-56	76.5
Үүнээс: нас баралт	хүн	5	3	-2	60.0
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	203	184	-19	90.6
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	189	161	-28	85.2
8. Амаржсан эх	хүн	148	122	-26	82.4
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	0	0	0	#DIV/0!
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	2	2	0	100.0

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн 01 сард

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
	Тоо				
Дүн	122	0	123	2	0
Айраг					
Алтанширээ					
Даланжаргалан					
Дэлгэрэх					
Иххэт					
Мандах					
Өргөн					
Сайхандулаан					
Улаанбадрах					
Хатанбулаг	1		1		
Хөвсгөл					
Эрдэнэ					
Сайншанд	89		90	1	
Замын - Үүд	32		32	1	

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 01 сард

Үзүүлэлт	2020 I	2021 I	Өсөлт	
	Тоо	Тоо	Тоо	Хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	121	28	-93	23.1
Вируст гепатит	0	0	0	0.0
Сүрьеэ	6	7	1	0.0
Тэмбүү	12	6	-6	50.0
Заг хүйтэн	25	9	-16	36.0
Трихоминиаз	13	5	-8	38.5
Цусан суулга	3	0	-3	FALSE
Бусад	62	1	-61	1.6

Тайлбар -²-дахин их

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.1 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭНИЙ ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 01 сард

Боловсролын түвшингээр	2018 I	2019 I	2020 I	2021 I	2021 I 2018 I	2021 I 2020 I
	хүний тоо				хувь	
ДҮН	1 025	879	243	276	26.9	113.6
Үүнээс: Эмэгтэй	517	417	114	139	26.9	121.9
Магистр, доктор	4	1	1	2	50.0	0.0
Дээд боловсролтой	230	128	50	82	35.7	164.0
Тусгай дунд	55	37	15	22	40.0	146.7
Техник мэргэжлийн	83	52	23	15	18.1	65.2
Бүрэн дунд	568	571	129	135	23.8	104.7
Бүрэн бус дунд	57	63	18	14	24.6	77.8
Бага	9	10	4	2	22.2	50.0
Боловсролгүй	19	17	3	4	21.1	133.3

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 01 сард

	Бүртгэлтэй иргэдийн тоо		Ажилд орсон иргэдийн тоо		Шинээр нэмэгдсэн иргэдийн тоо	
	2020 I	2021 I	2020 I	2021 I	2020 I	2021 I
ДҮН	0	276	0	15	0	105
Айраг	0	8	0	0	0	2
Алтанширээ	0	6	0	0	0	1
Даланжаргалан	0	5	0	0	0	1
Дэлгэрэх	0	0	0	0	0	0
Иххэт	0	0	0	0	0	0
Мандах	0	6	0	0	0	0
Өргөн	0	3	0	0	0	0
Сайхандулаан	0	2	0	0	0	0
Улаанбадрах	0	3	0	0	0	0
Хатанбулаг	0	9	0	0	0	5
Хөвсгөл	0	0	0	0	0	0
Эрдэнэ	0	10	0	0	0	3
Сайншанд	0	160	0	6	0	60
Замын - Үүд	0	64	0	9	0	33

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, жил бүрийн 01 сард

Салбарын ангилал	2020 I	2021 I
	Тоо	
Бүгд	0	19
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	0	0
Уул уурхай олборлох аж үйлдвэр	0	0
Боловсруулах үйлдвэрлэл	0	3
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0	2
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент	0	0
Барилга	0	0
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	0	0
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	0	2
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	0	0
Мэдээлэл, холбоо	0	0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0	0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0	0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0	0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0	5
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын	0	0
Боловсрол	0	0
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	0	2
Урлаг, үзвэр,тоглоом наадам	0	0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0	5
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн өөрийн	0	0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0	0

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, жил бүрийн 01 сард

Үзүүлэлт	2020 I	2021 I
	Тоо	
Бүгд	0	19
Менежер	0	0
Мэргэжилтэн	0	4
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	0	1
Контор, үйлчилгээний ажилтан	0	5
Худалдаа, үйлчилгээний ажилтан	0	4
ХАА, ой загас агнуурын ажилтан	0	0
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний	0	5
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	0	0
Энгийн ажил мэргэжил	0	0
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	0	0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангиллаар жил бүрийн 01 сард

Үзүүлэлт	2020 I		2021 I	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	тоо		тоо	
Бүгд	0	0	15	9
Менежер	0	0	0	0
Мэргэжилтэн	0	0	4	2
Техникч болон туслах дэд/мэргэжилтэн	0	0	1	1
Контор, үйлчилгээний ажилтан	0	0	5	4
Худалдаа, үйлчилгээний ажилтан	0	0	2	2
ХАА, ой загас агнуурын ажилтан	0	0	0	0
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	0	0	3	0
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	0	0	0	0
Энгийн ажил мэргэжил	0	0	0	0
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	0	0	0	0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 01 сард

Үзүүлэлт	2020 I	2021 I	2021 I 2020 I
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	2 814.0	3 882.8	138.0
Тэтгэврийн даатгалын сан	1781	2 606.0	146.3
Тэтгэмжийн даатгалын сан	199.9	274.1	137.1
Эрүүл мэндийн даатгалын сан	469.1	653.0	139.2
ҮОМШӨ*-ний даатгалын сан	287.3	284.8	99.1
Ажилгүйдлийн даатгалын сан	76.7	64.9	84.6
Нийгмийн даатгалын сангийн зарлага	4 327.8	4 771.7	110.3
Тэтгэврийн даатгалын сан	3307.6	3 832.7	115.9
Тэтгэмжийн даатгалын сан	364.3	258.1	70.8
Эрүүл мэндийн даатгалын сан	389.2	489.1	125.7
ҮОМШӨ*-ний даатгалын сан	99.7	109.4	109.7
Ажилгүйдлийн даатгалын сан	167.0	82.4	49.3

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 01 сард

Үзүүлэлт	2020 I	2021 I	2021 I 2020 I
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	3693	3732	101.1
Албан журмаар даатгуулагчид	3558	3576	100.5
Аж ахуй нэгж, байгууллага	1545	1558	100.8
Төсөвт байгууллага	2013	2018	100.2
Сайн дураар даатгуулагчид	135	156	115.6
2. Тэтгэвэр авагчдын тоо	8806	9394	106.7
Өндөр насны тэтгэвэр	6378	6889	108.0
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1292	1380	106.8
Тэжээгчээ алдсаны	511	486	95.1
Цэргийн тэтгэвэр	470	492	104.7
ҮОМШӨ*-ний	155	147	94.8
	сая төгрөг		
3. Олгосон тэтгэвэр	3 405.8	3 905.9	114.7
Өндөр насны тэтгэвэр	2 470.6	2 895.3	117.2
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	375.0	437.8	116.7
Тэжээгчээ алдсаны	153.9	161.7	105.1
Цэргийн тэтгэвэр	306.6	336.9	109.9
ҮОМШӨ*-ний	99.7	74.2	74.4

Тайлбар: *-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс



3.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сумаар

Сумын нэр	2020 I	2021 I	2021 I 2020 I
	сая төгрөг		хувь
ДҮН	2814.0	3882.8	138.0
Айраг	59.2	51.3	86.7
Алтанширээ	26.1	24.5	93.9
Даланжаргалан	80.7	87.4	108.3
Дэлгэрэх	35.9	13.2	36.8
Иххэт	57.8	55.6	96.2
Мандах	35.5	30.9	87.0
Өргөн	77.7	61.0	78.5
Сайхандулаан	37.9	27.8	73.4
Улаанбадрах	25.1	12.4	49.4
Хатанбулаг	64.2	62.7	97.7
Хөвсгөл	28.6	25.3	88.5
Эрдэнэ	48.8	52.2	107.0
Сайншанд	1445.0	2385.8	165.1
Зүүнбаян баг	127.2	127.3	100.1
Замын-Үүд	664.3	865.4	130.3

3.4 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сумаар

Сумын нэр	2020 I	2021 I	2021 I 2020 I
	сая төгрөг		хувь
ДҮН	4327.8	4771.7	110.3
Айраг	219.4	235.6	107.4
Алтанширээ	81.5	94.5	116.0
Даланжаргалан	222.3	187.0	84.1
Дэлгэрэх	96.8	117.8	121.7
Иххэт	153.1	170.5	111.4
Мандах	100.5	106.7	106.2
Өргөн	157.5	151.4	96.1
Сайхандулаан	69.5	80.8	116.3
Улаанбадрах	94.9	107.8	113.6
Хатанбулаг	165.3	187.4	113.4
Хөвсгөл	79.0	85.9	108.7
Эрдэнэ	156.6	175.6	112.1
Сайншанд	1752.8	2008.1	114.6
Зүүнбаян баг	163.9	145.2	88.6
Замын-Үүд	814.7	917.4	112.6



3.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 01 сард

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2021 I 2020 I	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2021 I 2020 I
	2020 I	2021 I		2020 I	2021 I	
	тоо		хувь	сая төгрөг	хувь	
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	7470	6006	80.4	523.2	595.7	113.9
1. Халамжийн тэтгэвэр	1232	1252	101.6	218.1	371.7	170.4
Ахмад настны тэтгэвэр	82	98	119.5	14.2	29.5	207.8
Хөдөлмөрийн чадвараа 50-69% алдсан ХБИ	344	328	95.3	59.7	97.5	163.3
Хөдөлмөрийн чадвараа 70%-с дээш алдсан ХБИ	431	456	105.8	75.4	133.0	176.4
16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр	1	1	100.0	0.2	0.3	165.5
Өрх толгойлсон эх/эцэг/-ийн халамжийн тэтгэвэр	0	0		0.0	0.0	
Тэжээгч нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэвэр	374	369	98.7	68.6	111.4	162.4
2 Халамжийн тэтгэмж	817	1024	125.3	70.0	101.6	145.1
Эмнэлгийн хяналтад байдаг асаргааны тэтгэмж	0	0		0	0.0	
Ахмад настныг асарч байгаа иргэнд олгох тэтгэмж	380	481	126.6	28.9	43.3	149.9
Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18-аас дээш насны хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	204	240	117.6	23.1	31.2	134.8
Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхдийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	189	250	132.3	14.3	22.0	154.2
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	38	43	113.2	3.3	4.3	127.9
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	3	4	133.3	0.2	0.3	148.2
Тэжээн тэтгэх хүүхэдгүй, төрөл садангийн хүнгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн	3	6	200.0	0.2	0.5	283.3
3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал	0	0	0.0	0	0	0.0



Хүснэгт 3.5-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2021 I 2020 I	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2021 I 2020 I
	2020 I	2021 I		2020 I	2021 I	
	тоо		хувь	сая төгрөг		хувь
4. Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	218	288	132.1	36.2	75.2	207.9
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	212	244	115.1	35.7	72.5	202.9
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	6	44	733.3	0.4	2.6	628.6
5. Нийгмийн халамжийн сан	6	2	33.3	7.2	2.4	33.3
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн		1	0.0	0.0	1.2	0.0
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	5	1	20.0	6.0	1.2	20.0
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, 4 ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон иргэн	1		0.0	1.2		0.0
6. Бусад халамжийн дүн	5197	3440	66.2	191.7	44.8	23.4
